

АГУУЛГА

ОРШИЛ.....	3
I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	4
I.1. Төслийн зорилго.....	4
I.2. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	4
I.3. Ордын нөөц.....	4
I.4. Ордын ашиглалтын технологи.....	4
I.5. Ордын БОННУ.....	4
I.6. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмын хэрэгжилт.....	4
II. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
II.1 Ордын байршил.....	5
II.2. Физик, газарзүй, эдийн засаг, дэд бүтэц.....	5
II.3. Ордын геологийн тогтоц.....	8
III. ИЛ УУРХАЙ ТӨЛӨВЛӨЛТ.....	8
III.1. Ашиглалтын системийн параметрууд.....	9
III.2. Ашиглалтын технологи, механикжуулалтын бүтэц.....	9
III.3. Уулын ажлын горим.....	9
III.IV. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө.....	10
III.5. Хүдэр олборлолтын төлөвлөгөө.....	Error! Bookmark not defined.
III.6. Хөрс хуулалтын төлөвлөгөө.....	11
III.6.1. Шимт хөрс хуулах зузаан.....	12
III.6.2. Шимт хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө.....	13
III.6.3. Хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө.....	13
III.7. Ил уурхайн авто замын тооцоо.....	13
IV. Усан хангамж.....	14
IV.1. Ус хангамжийн эх үүсвэр.....	15
IV.1.2. Ашиглах усны хэмжээ.....	15
IV.1.3. Ажилчдын унд-ахуйд усны хэрэглээ.....	15
IV.1.4. Ил уурхайн усны хэрэглээ:.....	15
IV.1.5. Барилга байгууламж.....	15
V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	16
V.1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	16
V.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	16
V.2. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга.....	17
V.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	17
V.4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	17
V.5. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	17
V.6. Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	17
V.7. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
V.8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
V.9. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө.....	19
V.10. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
V.11. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
VI. Тэр бум мод үнэдсэний хөтөлбөрийн хүрээнд.....	22
VI.1. Мод тарихын экологийн ач холбогдол.....	22
VI.2. Мод, сөөг болон түүний бүтэц, зарим үүрэг.....	23

VII. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	23
VIII. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	24
IX. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	25
X. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө төлөвлөгөө	25
XI. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
XII. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
XII.1. Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах	27
XII.2. Хог хаягдлын тооцоо, судалгаа	27
XII.3. Энгийн болон ахуйн хог хаягдал	28
XII.4. Үйлдвэрлэлийн хог хаягдал	28
XII.5. Аюултай хог хаягдал.....	29
XII.6. Шингэн хаягдал	29
XII.7. Нүхэн жорлон	29
XII.8. Угаадасны нүх	29
XII.9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээ.....	30
XII.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	31
XIII. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	32
XIV. БОМТ-ний төсвийн нэгтгэл.....	33

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн дараах солбицлууд.....	5
Хүснэгт 2. Ил уурхайн ашиглалтын технологийн схем.....	9
Хүснэгт 3. Уурхайн ажлын горим.....	9
Хүснэгт 4. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө	10
Хүснэгт 5. Хүдэр олборлолтын төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
Хүснэгт 6 . Хөрс хуулалтын төлөвлөгөө	11
Хүснэгт 7. Гүний худгийн мэдээлэл	Error! Bookmark not defined.
Хүснэгт 8. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ...	18
Хүснэгт 9. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 10. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд.....	19
Хүснэгт 11. Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 12. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 13. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	24
Хүснэгт 14. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
Хүснэгт 15. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	25
Хүснэгт 16. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	25
Хүснэгт 17. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
Хүснэгт 18. Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдал	28
Хүснэгт 19. Төслийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдал	29
Хүснэгт 20. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	31
Хүснэгт 22. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	32
Хүснэгт 23. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	33
Хүснэгт 24. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл	33

ОРШИЛ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Түшэцийн” хайлуур жоншны ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутагт төвлөрүүлэхэд оршино.

Манай компани нь БОАЖ сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу энэхүү 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Ордын геологийн тогтоц, хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанар, олборлолтын арга, механикжуулалтын бүтэц, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг харгалзан экскаватор-автосамосвалын хослол бүхий автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системийг авч үзсэн. ТЭЗҮ батлагдсан байна.

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн эхний жилд хөрс хуулалтын ажлыг 3-р сараас 10-р сарын 15 хүртэл, хүдэр олборлолтын ажлыг 3-р сарын дунд үеэс 10-р сарыг дуустал үргэлжилнэ.

Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөлтийг ордын уул геологийн нөхцөл, элс угаан баяжуулах хэсгийн хүчин чадал болон олборлолтод ажиллах техникүүдийн хүчин чадалд тулгуурлан гүйцэтгэсэн. Орд ашиглалтын 2024 оны хугацаанд нийт 70.05 мян.м³ хүдэр олборлож, нийт 152.10 мян.м³ хөрс хуулна.

2024 онд уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад нийт 6.9 га талбай эвдрэлд өртөх бөгөөд үүнээс ил уурхайн уулын ажилд 1.7 талбай га, хүдэр баяжуулах талбайд 1.2 талбай га, технологийн зам тавихад 1.5 га талбай, хөрсний гадаад овоолго байршуулахад 2.3 га талбай, шимт хөрс байршуулахад 0.2 га талбай тус тус эвдрэлд эвдрэлд өртөнө.

Ил уурхайн ашиглалтын систем нь ордын уул техникийн нөхцөл, хүдрийн биетийн хэлбэр ба байршил, хөрсний зузаан зэрэгт үндэслэн ил аргаар, өрөмдлөг тэсэлгээ - экскаватор - автосамосвалын хослол бүхий авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ -ийг батлагдсан тул ордын хүдрийн нөөцийг бүрэн олборлож дуусах хүртэл уурхайн карьерт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

Иймд 2024 онд уурхайн карьерт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

Компани нь байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нэгэнт болсон сөрөг нөлөөллийг арилгах, болсны дараа арга хэмжээ авах гэсэн дараалал баримтлах бөгөөд төсөл хэрэгжих нутгийн иргэд болон сонирхогч талуудад төслийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зарчим баримтлан ажиллана.

I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

I.1. Төслийн зорилго.

Түшэц ордыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагааг явуулж, эдийн засгийн хувьд үр ашигтайгаар, байгалийн баялгийг зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, мөн компанийн ажилчид болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

I.2. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.

АМГТГ-ын Геологи, Уул уурхайн Кадастрын хэлтсийн даргын 2014.12.26-ны өдрийн шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Түшэц ” нэртэй 146.13 га талбайд ашигт малтмал ашиглах MV-017694 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон.

I.3. Ордын нөөц.

Ордод 2012 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн ЭБМЗ-ийн 2014 оны 06 сарын 13-ны өдрийн ХХ-10-04 тоот дүгнэлт, түүний дагуу гарсан АМГ-ын даргын 2014 оны 07 сарын 09-ны өдрийн Н-121 тоот тушаалаар тус ордын нийт нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэргээр 187873.2 тн хүдэр, бодитой (В) нөөцийг 122436.3 тн хүдэр, боломжтой (С) нөөцийг 65436.86 тн хүдэрээр хүлээн авсан байна.

I.4. Ордын ашиглалтын технологи.

Ил уурхайн ашиглалтын систем нь ордын уул техникийн нөхцөл, хүдрийн биетийн хэлбэр ба байршил, хөрсний зузаан зэрэгт үндэслэн ил аргаар, өрөмдлөг тэсэлгээ - экскаватор - автосамосвалын хослол бүхий авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ -ийг батлагдсан.

I.5. Ордын БОННУ

Төсөл хэрэгжүүлэгч нь 2019 онд Байгаль орчны үнэлгээний “Газар Чандмань” ХХК -иар “Түшэцийн хайлуур жонш ордыг ил аргаар ашиглах” төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэмэлт тодотголыг боловсруулан батлуулсан.

I.6. Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжийн сонголт.


Баяжуулах хэсэг нь гар аргаар ялгах технолгиор ажиллах баяжуулалтад хүлээн авах бункер, бутлуур, шигшүүр болон конвейер гэсэн үндсэн тоног төхөөрөмжүүд ашиглагдана. Жоншны хүдэр ангилан баяжуулах үеийн тоо чанарын хэмжээ, баяжуулах хэсгийн хүчийн чадлыг үндэслэн тоног төхөөрөмжийн тооцоог хийж гүйцэтгэсэн.

II. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

II.1 Ордын байршил.

Төслийн талбай нь засаг захиргааны харьяаллаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт, Айраг сумын төвөөс баруун хойд зүгт 38км зайд, Улаанбаатар хотоос төмөр замын дагуу зүүн урд зүгт 292км зайд үүнээс Чойр өртөө хүртэл 220км замаар засмал замаар, цааш ердийн хөрсөн замаар 72км явж хүрэх зайд байрлана. Хэнтий аймгийн Дархан сумын Бор-Өндөр тосгоноос баруун урд зүгт 15км зайд оршино.

Зураг 1. Ордын байршил



Ордын нь байр зүйн зургийн L-49-63 хавтгайд байрлах ба тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн дараах солбицлуудаар хязгаарлагдана.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн дараах солбицлууд

№	Уртраг	Өргөрөг
1	109° 0' 31.73"	45° 48' 3.63"
2	109° 0' 31.73"	45° 48' 24.1"
3	108° 58' 44.67"	45° 48' 24.1"
4	108° 58' 44.67"	45° 48' 3.61"

II.2. Физик, газарзүй, эдийн засаг, дэд бүтэц.

Газрын гадаргуу: Судалгааны талбайн төвийн болон хойд хэсгүүдээр далайн түвшингээс дээш 1300-1600 метрт өргөгдсөн жижиг гүвээлэг, толгодлог гадаргуу зонхилох

ба Онол-Уул, Чойрын богд уул, Их сансар, Чингэл, Баянцогт гэх мэт уулууд нь хамгийн өндөр цэгүүд бөгөөд далайн түвшнээс дээш 1485-1695 метрт хэлбэлзэнэ.

Гол нуурууд: Судлагдсан нутаг дэвсгэрийн хэмжээг тогтмол урсгал ус байхгүй. Булгийн усаар тэжээгддэг жижгэвтэр горхиуд, тухайлбал Хулгарын гол, Хөндлөн, Хашаат, Уулзвар, Цагаан-эрэг, Цоорхой, Хар-хад, Цагаан усны гол зэрэг нь нийт талбайд тархсан ба үүнээс Цоорхойн голыг рашааны төрөлд багтаан нутгийн ардууд ундаанд өргөн хэрэглэдэг. Дээрхи горхиуд нь ундарга багатай, урсгал нь уртаашаа зуугаад метр үргэлжилдэг.

Цаг уур: Уур амьсгалын хувьд халуун хүйтний улирал болон өдөр шөнийн цагт хамгийн их зөрүүтэй ажиглагддаг. Зун нь дулаан урт үргэлжлэх ба өвөл нь хамгийн хүйтэн үе нь их богино үргэлжилнэ. Хамгийн хүйтэн сар нь 12-р сараас /-150- -210С/ 1-р сар. Хамгийн халуун сар нь 7,8-р сар /+200 - +300С/ Хамгийн их температур +390С хүйтэн нь -390С эндээс үзэхэд жилийн дундаж температур +40С. Жилд буух хур тунадасны хэмжээ дундаж нь 150мм. Ихэнхдээ хуурайшилтай агаартай харьцангуй чийгшил 50%-иас хэтрэхгүй. Гол чийг өгөх зүйл нь зуны цагт буух хур тунадаснаас шалтгаална. Анхны цас 9-р сарын дундуур болон 10-р сарын эхээр бууна. 4-р сарын төгсгөл болтол цас бүрэн хайлж дуусахгүй. Салхины хурд энэ районд тогтмол 4,4-10м/сек байдаг.


Ургамал амьтан: Өвс ургамлын хувьд уг район нь элсэн цөлийн болон говь хээрийн, хагас цөлийн ургамал зонхилно. Тус бүс газарт хөрсөн бүрхэвч жигд дэлгэрэн тархсан бөгөөд цайвар хүрэн, хүрэн хөрс шороо зонхилно. Ургамлын гол тархалт нь хөндий жалга дагадаг ба ихэнхдээ тачир, бутархаг ургамал, хааяа нэг ногоон дэвсэг газар тааралдана.

Амьтан: Амьтдын хувьд цагаан зээр, хулгана, алаг даага, төрөл бүрийн жигүүртэн, үүн дотроо болжмор, ногтруу, бүргэд, элээ шонхор элбэг тааралдана. Амьтнаас үнэг хярс туулай, зуны цагт тарвага зурам, хээрийн мэрэгчидээр хооллодог махчин шувуу, цагаан зээр, гүрвэл элбэг тааралдана. Хамгийн элбэг нь зун намрын цагт тарвага, зурам бэлчээрийн мэрэгч амьтад, намар өвлийн цагт цагаан зээрийн сүрэгтэй тааралдана.

Сум багийн хүн ам зүйн мэдээлэл


Тус суманд 2021 оны байдлаар 1408 эмэгтэй, 1575 эрэгтэй нийт 2983 хүн оршин сууж байна. Сумын хүн амын тоо сүүлийн 3 жилийн байдлаар хэвийн түвшинд бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа нь 49/51 харьцаатай байна.

Зураг 3. Даланжаргалан сумын хүн амын тоо, хүйсээр



Зэс уурхай байрших Өнгөт багийн хэмжээнд 486 хүн, 180 өрх бүртгэлтэй байгаа бөгөөд энэ нь сүүлийн 5 жил байнгын өссөн үзүүлэлттэй байна.


Зураг 4. Даланжаргалан сумын өрхийн тоо



Сум багийн малын тоо толгой


Даланжаргалан сум нь 2021 онд 5 багийн нийт 215.6 мянган мал тоологдсон. Сумын хэмжээнд нийт малын тоо сүүлийн гурван жилд өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд төсөл хэрэгжиж буй Өнгөт багт нийт сумын 34 хувь буюу хамгийн олон мал ноогдож байна.

Зураг 5. Даланжаргалан сумын нийт малын тоо



Өнгөт багт 2021 онд 72670 мал тоологдсон бөгөөд нийт малын 90.5 хувийг бог мал эзлэж байна.

Зураг 6. Өнгөт багийн малын тоо толгой мян.тоо /5 хошуу малаар/



II.3. Ордын нөөцийн тооцоо

"Түшэц" ордын хүдрийн нөөц В+С зэрэглэлээр 187873.2тн, CaF₂-ын нөөц 70085.83 тн, үүнээс В зэрэглэлээр хүдрийн нөөц 122436.3 тн, С зэргээр хүдрийн нөөц 65436.86 тн гэж нөөцийн тооцоог бодсон болно.

Хэсэгшил В-1 Энэ хэсэгшлийн талбайд /39 м хүртэл гүнд/ хайгуулын шугам I-V, цооног №1 ба канав №1-3, шүрф-1 хамрагдаж байгаа бөгөөд хүдрийн биетийн талбай 3547.73м², Хүдрийн биетийн уналын өнцөг 80 град хайлуур жоншны дундаж агуулга 35.57%, дундаж жинхэнэ зузаан нь 4.13м, нийт эзлэхүүн нь 14634.39 м³ болно. Хэсэгшлийн нөөцийг тооцоолон 38049.4 тн хүдэртэй бөгөөд хайлуур жонш нь 13436.5 тн гэж тогтоов.

Хэсэгшил В-2 талбайд /30-60 м хүртэл гүнд буюу 1200-1150 м-ийн түвшинд/ хайгуулын шугам IV- YI хооронд байрлана. Цооног № 2 ба канав № 4-6, шүрф-1 зэрэг малталтууд хамрагдана. Хэсэгшлийн нийт жинхэнэ талбай нь тооцоогоор 3335.65 м² болно. Хүдрийн биетийн уналын өнцөг 80 град дундаж жинхэнэ зузаан нь 4.72 м. Нийт эзлэхүүн нь 15750м³ болно. Хэсэгшлийн нөөцийг тооцоолон 40952.44 тн хүдэртэй бөгөөд хайлуур жонш нь 12850.06 тн гэж тогтоов. Хайлуур жоншны жигнэсэн дундаж агуулга 31.53% байна.

Хэсэгшил В-3 талбайн /43 м хүртэлх гүнд/ Хайгуулын шугам YI-VIII. Цооног-2, 3 Канав № 6, 7, 8 карьер 1, 2 зэрэг малталтууд хамрагдана. Хэсэгшлийн нийт талбай 4057.47м² бөгөөд хүдрийн биетийн уналын өнцөг 80 град дундаж жинхэнэ зузаан нь 4,11 м.

Нийт эзлэхүүн нь 16686.34м³ болно. Хэсэгшлийн нөөцийг тооцоолон 43384.5 тн хүдэртэй бөгөөд хайлуур жоншны нөөц 16729.06 тн. Хайлуур жоншны жигнэсэн дундаж агуулга 38.56% байна.

Хүснэгт№: 02 Түшэц” ордын нөөцийн нэгдсэн хүснэгт

Блокийн дугаар	Хүдрийн биетийн талбай м ²	Хүдрийн биетийн зузаан, м	Хүдрийн биетийн эзлэхүүн, м ³	Хүдрийн нөөц, тн.	CaF ₂ -ын дундаж агуулга, %	Хайлуур жоншны нөөц, тн.
В-1	3547.73	4.13	14634.39	38099.4	35.37	13456.5
В-2	3335.65	4.72	15750.94	40952.44	31.53	12850.06
В-3	4057.47	4.11	16686.34	43384.5	38.56	16729.06
С-1	1721.1	3.9	6712.29	17451.95	39.2	6840.29
С-2	2064.16	1.6	3302.16	8586.91	35.08	3012.29
С-3	2134	1.71	3638.47	9460.02	29.12	2754.76
С-4	1154.64	1.32	1524.12	3962.72	38.36	1522.87
С-5	2395.8	4.17	9990.48	25975.26	49.74	12920
Нийт В+С	20,411		72,239	187,873	37	70,086
В зэргээр	10,941		47,072	122,436	35	43,036
С зэргээр	9,470		25,168	65,437	38	27,050

III. ИЛ УУРХАЙ ТӨЛӨВЛӨЛТ

Ашиглалтын систем

Ордын геологийн тогтоц, хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанар, олборлолтын арга, механикжуулалтын бүтэц, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг харгалзан экскаватор-автосамосвалын хослол бүхий автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системийг авч үзсэн.

Ш.1. Ашиглалтын системийн параметрууд

Ордын геологийн тогтоц, хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанарыг үндэслэн уурхайн хажуугийн налуугийн өнцгийг 40°-48°-аар тогтоосон. Мөргөцгийн ажлын талбайн хамгийн бага өргөнийг техник аюулгүйн ажиллагааны дүрмийн шаардлагыг хангах хэмжээнд буюу тоног төхөөрөмжийн хэвийн ажиллах байдлыг хангах нөхцөлүүдийг үндэслэн дараах байдлаар тогтоов.

- Доголын ирмэгийн нурж болзошгүй аюулгүйн зурвасын өргөн- 3.0м
- Нэмэлт тоног төхөөрөмжид зориулсан аюулгүйн зурвас хүртэлх зай - 3м
- Хөдөлгөөний зурвасуудын тэнхлэг хоорондох зай - 3м

Ажлын талбайн хамгийн бага өргөн: $9.75+3 + 3 + 4.25+ 3 +3= 26\text{м}$ болно. Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмжүүдийн параметрийг үндэслэн мөргөцгийн өндрийг 10м-ээр тогтоосон. Ажлын талбайн өргөн 26-35м, уурхайн төгсгөлийн шатанд мөргөцүүдийг нэгтгэн мөргөцгийн өндрийг 10м-ээр хязгаарлана.

Ш.2. Ашиглалтын технологи, механикжуулалтын бүтэц

Уулын ажлын эхлүүлэхийн өмнө шимт хөрсийг 0.2-0.3 метр зузаантай хуулж шимт хөрсний овоолгод байршуулах ба үндсэн хөрс болон хүдрийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж, экскаватор – автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэж хөрсний гадаад овоолго болон хүдэр буулгах талбайд тус тус хураана.

Хүснэгт 2. Ил уурхайн ашиглалтын технологийн схем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1. Ухаж ачих 1.2. Тээвэрлэх 1.3. Овоолох
	2. Элс олборлолт	2.1. Ухаж ачих 2.2. Тээвэрлэх 2.3. Овоолох

Ш.3. Уулын ажлын горим

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн эхний жилд хөрс хуулалтын ажлыг 3-р сараас 10-р сарын 15 хүртэл, хүдэр олборлолтын ажлыг 3-р сарын дунд үеэс 10-р сарыг дуустал үргэлжилнэ.


Уурхайн хөрс хуулалтыг тэсэлгээгээр сийрэгжүүлэн гадаад овоолго үүсгэн хуулах бөгөөд Уулын ажил нь цаг агаарын саатал, төлөвлөгдөөгүй техникийн засвар үйлчилгээ, сул зогсолтоос хамааран эхний жилд баяр ёслол, амралтын өдрүүд 7 хоног, цаг агаараас хамаарсан сул зогсолт 14, уурхайн жилд ажиллах бодит хоног 150 хоног тус тус ажиллахаар байна.

Хүснэгт 3. Уурхайн ажлын горим

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Календарийн хоног	хоног	365
2	Баяр ёслол, амралтын өдрүүд	хоног	7
3	Цаг агаараас хамаарсан сул зогсолт	хоног	14
4	Төлөвлөгөөт сул зогсолт	хоног	30
5	Уурхайн жилд ажиллах бодит хоног	хоног	314
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

8	Ээлжийн сул зогсолт (цайны цаг)	цаг	1
9	Ээлжийн сул зогсолт (ээлж солилт, түлш тос, солилт)	цаг	1
10	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.84
11	Уурхайн жинд ажиллах бодит цаг	цаг	10.1
12	Уурхайн жилд ажиллах бодит цаг	цаг	6,343


Зураг. 8, Ил уурхайн ажлын горим



Ш.ИV. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Ил уурхайн уулын ажлын календарьчилсан төлөвлөлтийг ордын уул геологийн нөхцөл, элс угаан баяжуулах хэсгийн хүчин чадал болон олборлолтод ажиллах техникуудийн хүчин чадалд тулгуурлан гүйцэтгэсэн. Орд ашиглалтын 2024 оны хугацаанд нийт 70.05 мян.м³ хүдэр олборлож, нийт 152.10 мян.м³ хөрс хуулна.

График 1. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө



Хүснэгт 4. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	I-р улиралд	II-р улирал	III-р улирал	IV-р улирал	Нийт
Ил уурхай							
1	Хөрс хуулалт	мян.м ³	19	57	57	19	152
2	Хүдэр олболлолт	мян.тн	8.8	26.3	26.3	8.8	70
3	Хайлуур жониш	мян.тн	2.8	8.3	8.3	2.8	22.2

Ил уурхайн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэгчийн ажлын даалгаварт тусгасны дагуу одоо ашиглаж байгаа техникүүдийг үргэлжлүүлэн ашиглахаар тусгаж тооцсон болно.


Хүснэгт 6. Ил уурхайд ажиллах үндсэн техникийн тоо

Д/д	Тоног төхөөрөмж	Марк	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Экскаватор	Hyundai-520	Утгуурын багтаамж	м ³	3.2
3	Утгуурт ачигч	XZ656L	Утгуурын багтаамж	м ³	3
4	Бульдозер	D65A	Хусуурын хамах чадвар	м ³	3.8
5	Авто самосвал /Хөрс тээвэр/	336	Автосамосвалын техникийн даац	тн	25
6	Авто самосвал /Элс тээвэр/	336	Автосамосвалын техникийн даац	тн	25
7	Гэрэлт цамхаг	Terex RL4	Хөдөлгүүрийн чадал	кВт	6
8	Авто грейдер	SG21	Хусуурын урт	м	16
9	Усны машин	Dong Feng	Танкны багтаамж	тн	30
10	Түлш цэнэглэх машин	Hyundai-FL-2.5	Танкны багтаамж	тн	3

III.6. Хөрс хуулалтын төлөвлөгөө

Хөрс хуулалтад болон хүдэр олборлолтод ажиллах экскаваторыг компанид одоо ашиглаж байгаа 3.2м³ утгуурын багтаамжтай Hyundai-520 маркийн экскаваторыг уулын цулд сонгон ажиллуулахаар тусгасан болно.

Хүснэгт 6 . Уулын цулд ажиллах экскаваторын техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Техникийн үзүүлэлт	Техникийн зураг
1	Экскаваторын марк	-	Hundai 520	
2	Хутгуурын багтаамж	м ³	3.2	
3	Хутгалтын түвшин дэх хамгийн их радиус	м	11.6	
4	Утгалтын хамгийн их гүн	м	7.1	
5	Утгалтын хамгийн их өндөр	м	11.08	
6	Ачилтийн хамгийн их өндөр	м	7.5	
7	Арын эргэлтийн радиус	м	3.8	
8	Хөдөлгүүрийн чадал	кВт	232	
9	Явах хурд	км/цаг	4.7	
10	Масс	тн	53.4	
11	Түлшний савны багтаамж	л	610	
12	Явах ангийн өргөн	м	3.6	


13	Явах ангийн урт	м	5.4
14	Их өирийн өргөн	м	2.9
15	Их биеийн Өндөр	м	3.3

Ш.6.1. Ил уурхайн тээвэр

Уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтод ажиллах автосамосвалууд нь ил уурхайгаас хуулах хөрс болон олборлох элсийг уурхайн гол замаар тээвэрлэж хөрсийг хөрсний гадаад болон дотоод овоолгод, хүлрийг баяжуулах хэсэгт элсний түр овоолгод тээвэрлэн хураана.

Ил уурхайн хөрс болон элс тээвэрт төсөл захиалагчийн техникийн даалгаврын дагуу компанийн одоо ашиглаж байгаа 18.0 м³ тэвшний багтаамжтай HOWO-336 автосамосвал сонгохоор төсөлд тусгалаа.

Хүснэгт 8. Уулын цул тээвэрлэх автосамосвалын техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн үзүүлэлт	Техникийн зураг
1	Автосамосвалын марк	336		
2	Автосамосвалын техникийн даац	Тн	25	
3	Автосамосвалын өөрийн масс	Тн	25	
4	Автосамосвалын тэвшний геометр багтаамж	м3	18.63	
5	Хөдөлгүүрийн чадал	кВт	250	
6	Эргэлтийн радиус	М	10	
7	Тэвшний өргөн	М	2.3	
8	Тэвшний урт	М	5.4	
9	Тэвшний өндөр	М	1.5	
10	Дугуйн томьёо	-	6x4	
11	Дугуйн хэмжээ	-	12.00R20	
12	Түлшний савны багтаамж	Л	300	
13	Дугуйн тоо	Ш	10	
14	Урт	М	7.93	
15	Өргөн	М	2.49	
16	Өндөр	М	2.95	

Хөрс тээвэр. Ордын хувьд хэвтээ уналтай тул тээвэртэй гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр уулын ажлыг явуулахаар төлөвлөсөн. Тус төслийн хувьд ашиглалтын эхнээс ашиглагдсан хоосон орон зайг дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж, уулын ажилтай хамт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх боломжтой байна.

Хөрс тээвэрлэх автосамосвалын бүтээлийн тооцоог хийхдээ задгай мөчлөгөөр ажиллахаар автосамосвалын тоог тооцсон бөгөөд хөрс тээвэрт жилд 4 ш байхад бүтээл болон нөөцийн хувьд бүрэн хүрэлцээтэй байна.

Хүдэр тээвэр. Хөрсийг гадаад овоолго руу тээвэрлэн овоолгод овоолсны дараа хөрс тээврийн автосамосвалууд ил уурхайгаас хүдэр баяжуулах хэсгийн хүдрийн түр овоолго руу тээвэрлэнэ. Хүдэр тээвэрлэх автосамосвалын бүтээлийн тооцоог хийхдээ задгай

мөчлөгөөр ажиллахаар автосамосвалын тоог тооцсон бөгөөд элс тээвэрт жилд 4 ш байхад бүтээл болон нөөцийн хувьд бүрэн хүрэлцээтэй байна.


Ш.6.1. Шимт хөрс хуулах зузаан

Хуулалтад хамрагдах үржил шимт болон потенциал үржил шимт хөрсний үе давхаргын зузааныг төслийн талбайд хийсэн хөрсөн бүрхэвчийн үржил шимт байдлын түвшний үнэлгээ, үндсэн хэв шинж ба дэд хэв шинжүүдийн хөрсний зүсэлтийн бие даасан генетик горизонтуудын хаяалбаруудын тус тусын үржил шимт байдлын үнэлгээ дээр үндэслэн үржил шимт хөрсийг 20 см-ээр MNS 5916:2008 стандарт шаардлагын дагуу Бульдозероор хуулж хадгална. 2024 онд 6.9 га талбайгаас 13.8 мян.м³ шимт хөрс хуулах ба 0.2 га талбайд байршина.

Ш.6.2. Шимт хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө

Даланжаргалан сумын хувьд нутгийн зүүн болон төвийн хэсгээр нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрс тархсан. Харин нутгийн өмнө болон зүүн урд хэсгээр нунтаг карбонатлаг хүрэн хөрс, хойд болон баруун хэсгээр нунтаг карбонатлаг хар хүрэн хөрс, тус тус зонхилон тархсан байна.


Зураг 9. Шимт хөрсийг бульдозероор хуулах технологийн бүдүүвч



Ш.6.3. Хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө

Шороон ордыг ашиглах үед хөрсний гадаад овоолгыг автосамосвалаар тээвэрлэн бульдозерын тусламжтай овоолго үүсгэнэ. 2024 оны хугацаанд нийт 113.554 мян.м³ хөрс хуулж гадаад овоолго үүсгэх бөгөөд овоолгын сийрэгжсэн хэмжээ 147.62 мян.м³ байна. Хөрсний гадаад овоолго байрших талбайн хэмжээ 2.3 га талбай байна.

Зураг 10. Хөрсний гадаад овоолго байгуулах паспорт



Ш.7. Ил уурхайн авто замын тооцоо

Уурхайн дотоод замд хөрс болон хүдэр тээврийн автосамосвалын хөдөлгөөний дундаж хурд нь автосамосвалын овор хэмжээ, замын ачаалал, хөдөлгөөний эрчим, аюулгүй

байдал зэргээс хамаарч дунджаар 25.0 км/цаг байхаар тооцлоо. Уурхайн дотоод зам нь 12 м-ийн өргөнтэй, гадаад зам нь 12 м-ийн өргөнтэй байна.

Уурхайн дотоод замд хөрс болон хүдэр тээврийн автосамосвалын хөдөлгөөний дундаж хурд нь автосамосвалын овор хэмжээ, замын ачаалал, хөдөлгөөний эрчим, аюулгүй байдал зэргээс хамаарч дунджаар ачаатай үед 15 км/цаг, хоосон үед 30 км/цаг байхаар тооцлоо. Уурхайн дотоод зам нь 12 м-ийн өргөнтэй, гадаад зам нь 12 м-ийн өргөнтэй байна. Автозамын техникийн нөхцөл нь замын норм дүрмийн дагуу хоёр урсгалтай, замын зорчих өргөн 5м, замын дагуугийн хамгийн их налуу 80%, 25 тн-ын даац бүхий автосамосвалуудыг нэвтрүүлэх чадвартай байна.

- Замын хөдөлгөөний зурвасын өргөн.
 $V_{хз} = 2(V_a + v_{хз}) + V_{мх} = 12 \text{ м}$
 V_a - автосамосвалын өргөн, м
 $v_{хз}$ - хамгаалалтын үурвасын өргөн, м
 $V_{мх}$ - Автосамосвал зөрөх үеийн аюулгүйн зай, м

$$V_{мх} = 0.5 + 0.005 \cdot V_a$$

V_a -автосамосвалын хурд, км/цаг


- Замын тойруугийн хамгийн бага радиус.

$$R_{\text{зmin}} = \frac{U_a^2}{127 * (\varphi_{х}) \pm i_{хн}} = 6.85 \text{ м}$$

Уурхайн орох траншей болон гадаргуугийн технологийн авто зам нь байгалийн ердийн хөрсөн хучилттай байна. Харин уурхайн орох траншей, Овоолго руу гарах замуудад техник аюулгүйн арга хэмжээний дагуу халтиргаа, гулсалтаас хамгаалж дайрган хучилт хийх, замыг байгуулах явцад гадаргуугийн уснаас хамгаалсан суваг, шуудуу татах арга хэмжээг тусгаж өгсөн.гад

Мөн уурхайгаас хөрс ачих талбай, ШТС, хотхон хүртэл явах автозамыг ердийн шороон зам байлгахар тусгасан болно. Уурхайн автозамын засварын ажилд уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөж байна

Зураг 11. Ил уурхайн автозамын паспорт



IV. Усан хангамж

Түшэцийн төмрийн ойр орчимд гадаргын урсгал ус байхгүй. Хүдрийн биетүүд дээр өрөмдөгдсөн 80м хүртэл гүнтэй цооногуудад усны давхарга илрээгүй, хөндий хоолойд өрөмдөгдсөн худгуудын усны түвшин нь хүдрийн биетүүдийн түшингээс доор

байрлалтай байдаг. Ордын гидрогеологийн нөхцөл нь хуурай, хөрсний болон гүний усны ямар нэгэн илрэл ажиглагдаагүй учир гидрогеологийн ямар нэгэн хүндрэл байхгүй.

IV.1. Ус хангамжийн эх үүсвэр

Унд ахуйн болон зам талбайн усалгааг гүний худгаас хангана гэж ТЭЗҮ-д тусгасан байна. Төслийн талбайд гүний худаг өрөмдөж усны хэрэгцээг хангана.

Ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 33 хүн ажиллах боловч уурхайд байрлах ажилчны тоо хамгийн ихдээ 20 хүн, нэг хүний хоногт хэрэглэх усны хэмжээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын хавсралтын дагуу тооцсон.

Усны хэрэглээ: Түшэц ордыг ашиглах үед цэвэр усны дараах үндсэн гурван хэрэглэгч байна. Үүнд:

- ✚ Ахуйн усны хэрэглээ
- ✚ Ил уурхай

IV.1.2. Ашиглах усны хэмжээ

Төслийн жилийн усны хэрэглээг БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оор тооцов.

IV.1.3. Ажилчдын унд-ахуйд усны хэрэглээ

Ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 33 хүн ажиллах бөгөөд нэг хүний хоногт хэрэглэх усны хэмжээг тооцоход 20 хүн $\times 50$ л/хон = 1.0 м³/хон (314.0 м³/жил). Уурхайн хотхоны ундны ус нь шинжилгээгээр чанар стандарт түвшинд гарсан.

IV.1.4. Ил уурхайн усны хэрэглээ:

Ил уурхайн усны хэрэглэгч нь уурхайн зам, талбайн усалгаа зарцуулах ус байна. Байгаль орчныг тоос шорооноос хамгаалах зорилгоор хур бороогүй хуурайшилттай өдөр уурхайн талбай, авто зам зэргийг усална. Зам талбайн усалгаанд нийт 3,000 м² талбайн усалгааг жилд нийт 20 удаа усална. $3,000$ м³/хон $\times 2$ л = 6.0 м³/хон (120 м³/жил);


Уурхайн хотхон 50ш суулгац тарихаар төлөвлөсөн бөгөөд 50ш модыг услахад хоногт 2.0 м², хоногт 2 удаа усална. 2.0×90 л/хон = 180.00 м³/жил.

IV.1.5. Барилга байгууламж

Төслийн хугацаанд ажилчдын хотхонд хамгийн ихдээ 33 хүн байрлах бөгөөд амрах байр, удирдлагын байр, засварын газар, гал тогоо, агуулах, угаалга, бие засах, шүршүүрийн байрууд байхаар төлөвлөсөн. Ажилчдын байр хүн амьдрахаар тохижуулсан гэр байх бол шүршүүр, угаалга, бие засах газар мөн засаж тохижуулсан 40 тн-ын 2 ширхэг контейнер байна. Удирдлагын байр болон гал тогооны байр нь сэндвичээр барьсан 1 давхар байр байна.

Засварын газар болон харуулын байруудыг сэндвичэн хавтангаар байгуулах ба сэлбэг, тос тосолгооны материалын агуулах нь контейнерууд байна. Мөн шатахуун түгээх станцыг байгуулна.

Зураг 13. Уурхайн хотхоны загвар



V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт: Түшэц уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2018 онд “Газар чандиань” ХХК-ийн боловсруулсан алтны шороон орд ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: Алтан дун уурхайн MV-017694 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хайлуур жонш ордыг ил аргаар ашиглах төсөл.


V.1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ



Зэмтийн төмрийн хүрд олборлох төслийн БОНБНУ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

V.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

БОННУ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хөрсний овоолгууд ил уурхай зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй.

Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

 Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох

-  Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникүүд агаар орчныг бохирдуулах
-  Хөрс болон элс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх

V.2. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга



“Сармайдээлт” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэмнэлттэй хэрэглэх, усны хэрэглээг хамгийн бага түвшинд хүргэх, үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн иргэдийн хэрэглээний усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажиллана.

V.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Түшэц уурхайн үйл ажиллагаагаар газрын гадаргад овоолго үүсэж гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх, зам, байгууламж баригдаж газрын гадарга эвдэгдэх, ил уурхайн ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаагаар газрын гадарга, хэвлий ухагдаж хоосон орон зай (ухмал) бий болох, газрын гадаргын суулт үүсэх, тул газрын гадарга, хэвлийн эвдрэлийг аль болох бага хэмжээнд байлгах шаардлагатай. ШТМ-ын агуулах, ШТС, ШТМ алдагдсанаар газрын гадарга, хэвлийг бохирдуулах сөрөг нөлөөллүүд үүснэ.

V.4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаа, олборлолт, ашигт малтмал ашиглах, автозам байгуулах, ашиглах үед үүсэх дараах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоод байна. Үүнд:



-  Газар ашиглалтын үед хөрсөн бүрхэвч алдагдах
-  Хуулсан шимт хөрсийг зүй зохистой хадгалаагаагүйгээс салхинд хийсэн, үржил шим алдагдах.

V.5. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаа, тээврийн хөдөлгөөн, зөвшөөрөлгүй шороон зам ашигласнаас ургамлын нөмрөг нөлөөлөлд өртөж доройтох, дарагдах, устах эрсдэлүүдийг тооцсон байна.

V.6. Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр Алтан дун уурхайн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт үзүүлж болзошгүй дараах нөлөөллийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд:

-  Амьдрах орчны шууд хомсдол
